

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ
ТАНИЛЦУУЛГА**

УЛААНБААТАР ХОТ
2025 он

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	2
1.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал.....	2
1.2. Монгол Улсын макро эдийн засгийн нөхцөл байдал.....	3
1.3. Монгол Улсын эдийн засгийн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл	4
1.4. Түүхий эдийн зах зээлийн хандлага	4
1.5. Монгол Улсын төсөв, санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал	5
1.5.1. Төсвийн орлого.....	5
1.5.2. Төсвийн урсгал зарлага.....	6
1.5.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, явц.....	6
1.5.4. Засгийн газрын гадаад зээл, тусламж	9
1.5.5. Засгийн газрын өр.....	10
БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ТОДОТГОЛ ХИЙХ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ.....	13
БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛ.....	14
3.1. Төсвийн орлого	14
3.2. Төсвийн урсгал зарлага	15
3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл тусламжийн ашиглалт:	15
3.3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт	15
1.5.6. Засгийн газрын гадаад зээл, тусламж	17
БҮЛЭГ 4. НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	20
4.1. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд.....	20
4.2. Төсвийн тусгай шаардлага	21

БҮЛЭГ 1. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал

Олон улсад тоглоомын дүрэм өөрчлөгдөж, гео-эдийн засгийн хуваагдал эрчимжлээ.

Дэлхийн томоохон гүрнүүдийн стратегийн өрсөлдөөн гүнзгийрч, олон улс дах хүчний тэнцвэр шинэчлэгдэж байна. Тодруулбал, АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын “America First” бодлого нь гео-эдийн засгийн хуваагдлыг гүнзгийрүүлж, улс орнууд найдвартай түншүүдтэй хамтрах хандлага нэмэгдлээ. Ингэснээр, улс орнуудад уламжлалт чөлөөт худалдааны тогтолцоо өөрчлөгдөж, урт хугацаанд өндөр ач холбогдолтой, найдвартай түншүүдтэй хамтрах хандлага нэмэгдэж байна.

АНУ-ын шинэ тарифын бодлогууд нь үйлдвэрлэлийн салбаруудад сөргөөр нөлөөлж эхэллээ.

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп 180 улсад суурь тариф, 60 орчим улсад харилцан тариф, автомашин, хагас дамжуулагчид 25%, ган, хөнгөн цагаанд 50%-ийн тарифыг тус тус ногдуулж худалдааны дайны цар хүрээг хурдацтай тэлсэн. Үүнээс үүдэн, АНУ-ын Ford, GM зэрэг томоохон үйлдвэрлэгчдийн борлуулалт буурч, жижиг нийлүүлэгчид дампуурлаа зарлаж эхэлсэн. Улмаар, АНУ-БНХАУ-ын хоёр дахь хэлэлцээрийн хүрээнд газрын ховор элементийн экспортын хязгаарлалтыг зогсоох тохиролцоонд хүрч, хагас дамжуулагч, технологийн салбарын уналтаас сэргийлэх нөхцөлийг бүрдүүллээ.

БНХАУ экспортын өсөлтийг тогтвортой түвшинд хадгалсаар байна.

Энэ оны эхний 5 сарын байдлаар БНХАУ-аас АНУ-руу чиглэсэн экспорт 10 хувиар буурсан ч, Тайланд, Индонез зэрэг Азийн улсууд руу хийсэн экспорт 17-20 хувиар өссөн нь нийт экспорт 6.0 хувиар өсөхөд эергээр нөлөөллөө. Тус улсын Засгийн газраас энэ онд эдийн засгийн өсөлтийг 5 хувьд хүргэх зорилт тавьж, үлдэх хугацаанд тарифаас үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дотоодын эрэлт, үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх бодлого баримтлахын сацуу Зүүн өмнөд Ази, Африк, Латин Америк, Төв Азийн улс орнууд руу хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхээр зорьж байна.

Дэлхийн эдийн засгийн төлөв байдал удааширч байна.

Худалдааны дайн, дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдлаас үүдэн олон улсын байгууллагууд эдийн засгийн төсөөллийг бууруулж эхэллээ. Тухайлбал, Дэлхийн банк 2025 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөвийг бууруулж 2.3 хувьд хүргэлээ. Энэ нь 2008 оны санхүүгийн хямралаас хойших (цар тахлын үеийг тооцохгүйгээр) хамгийн сул түвшин байж болзошгүй байна.¹ Түүнчлэн, улс орнуудад инфляцын дарамт нэмэгдэж, Төв банкнууд бодлогын хүүг өндөр түвшинд хадгалснаар хөгжиж буй орнуудад валютын ханш суларч, санхүүжилтийн өртөг нэмэгдэж, олон улсын зах зээлээс хөрөнгө татахад хүндрэл бий болж байна.

¹ Дэлхийн банк, Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв тайлан, 2025.06

Ялангуяа Европ болон Төв Азийн бүс нутгуудад түүхий эдийн үнийн савлагаа сөргөөр нөлөөлж, эдийн засаг удаашрах төлөвтэй байна.²

Гадаад нөхцөл байдал Монгол Улсын эдийн засагт сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсын экспорт 2025 оны эхний 5 сарын байдлаар экспорт 5.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 15 хувиар буурлаа. Үүнд нүүрсний экспортын орлого өмнөх оны мөн үеэс 1.6 тэрбум ам. доллароор буурсан нь голлон нөлөөлөв. Хэдийгээр экспортыг эрчимжүүлэх Засгийн газрын хүчин чармайлтын үр дүнд нүүрсний биет хэмжээ эхний 5 сард 31.8 сая тоннд хүрч өмнөх оны түвшинд хадгалагдаж байгаа ч үнийн бууралтаас шалтгаалан орлого буурч байна.

Нүүрсний үнэ олон жилийн дунджаас доогуур түвшинд хүрээд байна.

2025 оны 5 сард Ганцмод боомт дээрх түүхий коксжих нүүрсний дундаж үнэ 802 юаньд хүрч, өмнөх оноос 40.8 хувиар буурсан байна. Энэ оны 1 сараас эхлэн БНХАУ-ын дотоодын олборлолт сэргэж, үйлдвэрлэл эрчимжиж, гангийн үйлдвэрүүд худалдан авалтаа танаснаар нийлүүлэлт эрэлтээс давж 2 сарын сүүлээр үнэ 5 орчим хувиар буурсан. Харин 3 сард гангийн үйлдвэрлэл нэмэгдэж, зах зээл түр хугацаанд тогтворжсон ч уг сэргэлт удаан үргэлжлээгүй ба 5 сарын дунд үе хүртэл үнэ алгуур буурсаар 825 юаньд хүрсэн. Харин 5 сарын дунд үеэс 6 сарын эхэн хүртэл коксжих нүүрсний үнэ ойролцоогоор 120 юаниар огцом буурлаа. Нүүрсний экспортын дундаж үнэ 2025 онд 70 ам.доллар орчим байх төлөвтэй байна.

Нүүрсний экспортын биет хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрэхээр байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 3 сарын 13-ны өдрийн 45 дугаар захирамжаар “Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх” Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг нийт 4 Засгийн газрын тогтоол, 6 Засгийн газрын хуралдааны тэмдэглэл батлуулж, тус хүрээнд Гашуунсухайт–Ганцмод боомтын төмөр зам холболтын гэрээг байгуулж, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ боомтуудын хил холболтыг эрчимжүүлэхээр шийдвэрлэлээ. Цашилбал, төмөр замын тарифыг 40-50 хувиар бууруулж, биржийн арилжааны холбогдох журмуудыг шинэчилснээр биржийн арилжаа сэргэх нөхцөлийг бүрдүүллээ. Үлдэх хугацаанд шинэ Засгийн газраас нүүрсний экспортын биет хэмжээг бууруулахгүй байхад анхаарч өмнөх оны түвшинд буюу 85 сая тонн-д хүргэхийг зорьж байна.

1.2. Монгол Улсын макро эдийн засгийн нөхцөл байдал

Эдийн засгийн нөхцөл байдал удаширсан байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2025 оны эхний улирлын байдлаар 19.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 6.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар тус тус өслөө. Үйлчилгээ болон хөдөө аж ахуйн салбарын сэргэлт эдийн засгийн өсөлтийг дэмжиж байгаа бол уул уурхайн

^{2:8} Дэлхийн банк, Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв тайлан, 2025.06

салбарын өсөлт удааширч, тээвэр, худалдаа, барилга, цэвэр татвар зэрэг салбарууд агшиж, өсөлтийг сааруулав.

Инфляц: Инфляц 2025 оны 5 дугаар сард 8.3 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.2 нэгж хувиар өсөж, өмнөх сараас 0.3 нэгж хувиар буурлаа. Инфляц өмнөх оны мөн үеэс өсөхөд цахилгааны төлбөр, орон сууцны түрээс, машин болон нийтийн тээврийн үйлчилгээ, хувцасны бүлгийн үнийн өсөлт нөлөөлсөн байна. Харин өмнөх сараас 0.3 нэгж хувиар буурахад хүнсний барааны үнийн өсөлт саарсан нь голлон нөлөөлжээ.

Импорт: 2025 оны эхний 5 сард 4.5 тэрбум ам.долларт хүрч, жилийн өсөлтийн хурд 3 хувьд хүрч саарлаа. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өмнөх оны мөн үеэс 18 хувиар өссөн бол аж үйлдвэрийн орцын импорт 10 хувиар, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 2 хувиар тус тус буурсан байна.

1.3. Монгол Улсын эдийн засгийн 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

Эдийн засгийн үзүүлэлтүүд батлагдсан хэмжээнээс буурахаар байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Эдийн засгийн өсөлт 2025 оны эцэст 6.0 хувь байхаар төсөөлж байна. Салбаруудаар авч үзвэл, байгаль цаг уурын таатай байдлын нөлөөгөөр төл бойжилт өндөр, том малын зүй бус хорогдол бага байж, хөдөө аж ахуйн салбар эдийн засгийн өсөлтийг голлон тэтгэх төлөвтэй байна. Мөн Оюутолгойн гүний уурхайн олборлолтын нөлөөгөөр баяжмал дахь зэс болон алтны агуулга нэмэгдэж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдэхээр хүлээж байна. Түүнчлэн, хөдөө аж ахуй болон уул уурхайн салбарын үйл ажиллагааны идэвхжилийн нөлөөгөөр боловсруулах салбарын өсөлт эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэх төлөвтэй байна.

Инфляц: Инфляц 2025 онд дунджаар 9.5 хувь орчимд байхаар тооцож байна. Жил дараалсан хөдөө аж ахуйн салбарын агшилтаас үүдэлтэйгээр махны нийлүүлэлт буурч, махны үнэ улирлын хандлагаасаа өндрөөр өсөх, цахилгааны тарифын нэмэгдлийн нөлөөгөөр дотоодын бараа, үйлчилгээний инфляц өсөх төлөвтэй байна. Цаашид геополитикийн тогтворгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, тээвэр логистикийн саатлаас үүдэн импортын инфляц нэмэгдэх эрсдэлүүд хэвээр байна.

Гадаад худалдаа: Нийт гадаад худалдааны бараа эргэлт 2025 оны эцэст 28.3 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 3.3 тэрбум ам.долларын ашигтай гарахаар байна. Нийт экспорт 2025 онд 15.8 тэрбум ам.доллар, нийт импорт 12.5 тэрбум ам.долларт хүрэхээр тооцоолж байна.

1.4. Түүхий эдийн зах зээлийн хандлага

Бусад голлох түүхий эдийн үнэ харьцангуй тогтвортой байна.

Зэс: Лондоны металлын бирж дээрх цэвэр зэсийн дундаж үнэ 2025 оны эхний 5 сарын байдлаар 9,340 ам.доллар болж, өмнөх оноос 2.1 хувиар өссөн байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар зэсийн дундаж үнэ 2025 онд 9,200 ам.доллар байхаар байна. Оюу толгойн гүний уурхайн нөлөөгөөр зэсийн баяжмал дахь цэвэр

зэс, алтны агуулга нэмэгдэж зэсийн баяжмалын экспорт энэ онд 2,030 мянган тоннд хүрэхээр байна.

Алт: Лондоны металлын бирж дээрх алтны дундаж үнэ 2025 оны эхний 5 сарын байдлаар 3,021 ам.доллар болж, өмнөх оноос 26.5 хувиар өссөн байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар алтны дундаж үнэ 2025 онд 2,900 ам.долларт хүрэхээр байна. Монгол улсын Засгийн газраас алтны экспортыг нэмэгдүүлэх зорилгоор “Алт-3” аяныг хэрэгжүүлж, 2025 онд нийт 16.5 тонн алт экспортлохоор төлөвлөж байна.

Төмрийн хүдэр: Төмрийн хүдрийн (62 хувийн агууламжтай) үнэ 2025 оны эхний 5 сарын байдлаар 101 ам.доллар болж, өмнөх оноос 7.9 хувиар буурлаа. Олон улсын шинжээчдийн таамаглалаар төмрийн хүдрийн дундаж үнэ 2025 онд 95 ам.долларт хүрэхээр байна. Монгол Улсын төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 2025 онд 72 ам.доллар байхаар тооцоолж байгаа бол экспортын биет хэмжээ 2025 оны эцэст 8,110 мянган тоннд хүрэхээр байна.

Газрын тос: Brent төрлийн газрын тосны дундаж үнэ 2025 оны эхний 5 сарын байдлаар 69 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 7.9 хувиар буурлаа. Олон улсын шинжээчдийн таамаглалаар Brent төрлийн газрын тосны дундаж үнэ 2025 онд 75 ам.долларт хүрэхээр байна. Монгол Улсын газрын тосны экспортын дундаж үнэ 2025 онд 75 ам.доллар байхаар тооцоолж байгаа бол газрын тосны экспортын биет хэмжээ 3,875 мянган баррельд хүрэхээр байна.

1.5. Монгол Улсын төсөв, санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал

1.5.1.Төсвийн орлого

Олон улсын геополитикийн нөхцөл байдал, худалдаа, эдийн засагт тулгарч буй тодорхойгүй нөхцөл байдлаас шалтгаалж, дэлхийн улс орнуудын эдийн засгийн өсөлт энэ 2025 онд буурах хандлагатай байна. Түүхий эдийн хэрэглээгээр тэргүүлэгч, урд хөрш БНХАУ-д үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлаас үүдэн эдийн засгийн өсөлт, гангийн хэрэглээ буурах эрсдэлтэй байгаа болно. Улмаар, манай улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ буурч, төсвийн орлого бүрдүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Экспортод гарч буй нүүрсний дундаж үнэ 2025 оны эхний 5 сарын байдлаар тонн тутамд 71.9 ам.долларт хэлбэлзсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 39 хувиар буюу 46.6 ам.доллаар буурсан. Нүүрсний үнэ буурснаас шалтгаалж манай улсын экспорт 2025 оны эхний 5 сарын байдлаар 5,424.6 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 15 хувиар буюу 932.9 сая ам.доллаар буураад байгаа болно.

Ийнхүү экспорт буурч байгаатай зэрэгцэн, манай улсын эдийн засгийн идэвхжил удааширч байна. Тодруулбал, энэ 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар эдийн засгийн өсөлт 2.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 5.5 нэгж хувиар буурчээ.

Дээр дурдсан нөхцөл байдлаас үүдэн Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2025 оны эхний 5 сарын байдлаар 11,381.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны

мөн үеэс 10.6 хувиар буюу 1,348.1 тэрбум төгрөгөөр буурч, төлөвлөгөөний биелэлт 89.9 хувь буюу 1,283.7 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт. 2025 оны эхний 5 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2024.05 ГҮЙЦ	2025.05 ГҮЙЦ	ЗӨРҮҮ
Нийт орлого	12,729.7	11,381.6	-1,348.1
Тогтворжуулалтын сан	192.9	186.2	-6.7
Үндэсний баялгийн сан	464.8	483.8	19.0
Тэнцвэржүүлсэн орлого	12,072.0	10,711.6	-1,360.4
Татварын орлого	11,318.1	10,035.4	-1,282.7
Татварын бус орлого	753.9	676.2	-77.7

1.5.2.Төсвийн урсгал зарлага

Нэгдсэн төсвийн урсгал зардал 2025 оны 05 дугаар сарын байдлаар 9,877.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан нь өмнөх оны мөн үеэс 1,509.6 тэрбум төгрөгөөр буюу 18 хувиар өссөн байна. Үүнд 2024 оны 2 дугаар улирлаас төрийн албан хаагчдын цалинг 10-20 хувиар, нийгмийн даатгалын тэтгэвэр авагчдын тэтгэврийг 100.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсний 2025 оны эхний улирлын нөлөөлөл, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн цалин, нийгмийн даатгал, халамжийн тэтгэврийг 6 хувиар нэмэгдүүлсэн зэрэг нь голлон нөлөөлжээ.

Нэгдсэн төсвийн цалин хөлсний зардал өнгөрсөн оны мөн үеэс 607.2 тэрбум төгрөг буюу 30.0 хувь, нийгмийн даатгал, халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал 496.0 тэрбум төгрөг буюу 16.8 хувиар, засгийн газрын урсгал шилжүүлгийн зардал 242.0 тэрбум төгрөгөөр буюу 24.3 хувиар, татаасын зардал 109.8 тэрбум төгрөг буюу 41.9 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт. 2025 оны эхний 5 сарын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2024.05 ГҮЙЦ	2025.05 ГҮЙЦ	ЗӨРҮҮ
Нийт урсгал зарлага	8,368.1	9,877.7	1,509.6
Бараа, ажил үйлчилгээний зардал	3,354.1	4,034.3	680.2
<i>Үүнээс Цалин хөлс</i>	2,023.9	2,631.1	607.2
Хүү	524.9	517.5	-7.4
Татаас	261.8	371.6	109.8
Урсгал шилжүүлэг	4,227.3	4,954.4	727.1

1.5.3.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, явц

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2025 онд 17.6 их наяд төгрөгийн санхүүжилт батлагдаж, 2018-2024 онд 12.7 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдсэн бол 2025 оны хувьд өмнөх онуудад эхлүүлсэн төслүүдээ дуусгах, бүсчилсэн хөгжлийг дэмжих томоохон дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх бодлогыг баримталсан.

Тухайлбал, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр 621 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 3,124.1 тэрбум төгрөг, концессын “Барих-шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулсан төслийн эргэн төлөлтөд 2 төсөл, арга хэмжээнд 107.1 тэрбум төгрөг тус тус батлагдсан бөгөөд үүнээс 29.4 хувь буюу 951.2 тэрбум төгрөгийг зам тээврийн салбарт, 6.1 хувь буюу 196.2 тэрбум төгрөгийг эрчим хүчний салбарт, 11.0 хувь буюу 354.1 тэрбум төгрөгийг инженерийн дэд бүтцийн чиглэлээр, 15.0 хувь буюу 472.7 тэрбум төгрөгийг боловсролын салбарт, үлдсэн санхүүжилтийг бусад салбарт хэрэгжүүлэхээр батлагдсан.

Харин 2025 онд батлагдсан санхүүжилтээс 61% нь өмнөх онуудаас үргэлжлэн хэрэгжиж буй төслүүд бол 36% нь шинээр хэрэгжүүлэх төслүүд байсан. Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувьд 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 395.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож гүйцэтгэл 12%-тай байна.

Хүснэгт. Санхүүжилтийн гүйцэтгэл, төслийн ангиллаар

АНГИЛАЛ	ТӨСЛИЙН ТОО	2025 ОНД САНХҮҮЖИХ ДҮН	САНХҮҮЖ- СЭН	ҮЛДЭГ- ДЭЛ	ГҮЙЦЭТ- ГЭЛ
Үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	511	1,964.4	342.8	1,621.6	17%
Шинээр хэрэгжүүлэх	110	1,159.7	41.8	1,117.9	4%
Концесс	2	107.1	11.0	96.1	10%
Нийт дүн	623	3,231.2	395.5	2,835.7	12%

Өмнөх онуудад эхлүүлсэн 2025 онд үргэлжлэн хэрэгжиж буй төслүүдийн хувьд санхүүжилтийн гүйцэтгэл 17.0% буюу 342.8 тэрбум төгрөг, шинээр хэрэгжиж байгаа төслүүдийн санхүүжилтийн гүйцэтгэл 4.0% буюу 41.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол концессын эргэн төлөлтөд 10.0% буюу 11.0 тэрбум төгрөгийг тус тус олгоод байна.

Хүснэгт. Санхүүжилтийн гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчаар

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	ТӨСЛИЙН ТОО	ТӨСӨВТ ӨРТӨГ	САНХҮҮ- ЖИХ ДҮН	ГҮЙЦЭТ- ГЭЛ	ХУВЬ	ҮЛДЭГ- ДЭЛ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ	2	1.0	1.0	-	0%	1.0
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	1	8.6	8.6	2.9	34%	5.6
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	1	1.5	1.5	-	0%	1.5
МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	4	189.8	51.4	6.2	12%	45.3
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	7	57.2	42.5	0.9	2%	41.6
МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	17	62.0	24.2	4.1	17%	20.1
МОНГОЛ УЛСЫН САЙД, ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ	1	2.4	2.4	-	0%	2.4

ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА						
МОНГОЛ УЛСЫН САЙД, 20 МИНУТЫН ХОТ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	3	48.2	15.7	-	0%	15.7
МОНГОЛ УЛСЫН САЙД, БООМТЫН СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	3	8.1	8.1	-	0%	8.1
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	2	11.3	11.3	8.1	72%	3.1
САНГИЙН САЙД	7	141.3	126.2	5.3	4%	121.0
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	18	148.3	108.6	4.2	4%	104.3
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД	1	1.0	1.0	-	0%	1.0
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	4	115.0	75.4	17.0	23%	58.4
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	12	89.0	80.8	1.2	2%	79.6
БОЛОВСРОЛЫН САЙД	190	1,330.6	472.7	83.0	18%	389.6
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	24	140.4	52.2	9.7	19%	42.5
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД	97	3,670.3	951.2	78.1	8%	873.1
СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	50	456.5	145.2	47.5	33%	97.7
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	54	1,137.2	354.1	38.4	11%	315.7
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	17	143.7	58.6	8.8	15%	49.8
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	7	49.6	35.7	-	0%	35.7
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	38	653.1	196.2	27.1	14%	169.1
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	39	433.6	193.1	23.9	12%	169.2
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	2	2.4	2.4	0.7	30%	1.6
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	3	6.5	4.6	-	0%	4.6
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	7	144.1	63.0	-	0%	63.0
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	5	73.2	29.8	16.9	57%	12.9
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	1	1.2	1.2	-	0%	1.2
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	1	0.3	0.3	-	0%	0.3
ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДАРГА	1	0.3	0.3	0.2	73%	0.1
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	1	2.7	2.7	-	0%	2.7
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	1	2.0	2.0	-	0%	2.0
УЛСЫН ТӨСВИЙН ДҮН	621	9,132.2	3,124.1	384.5	12%	2,739.5
КОНЦЕСС	2	298.4	107.1	11.0	10%	96.1
НИЙТ	623	9,430.5	3,231.2	395.5	12%	2,835.7

Худалдан авах ажиллагааны явц:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжүүлэх нийт 110 төсөл, арга хэмжээ батлагдсан, үүний 68 төсөл нь их засвар, тоног төхөөрөмж, ТЭЗҮ, зураг төсвийн ангилалд батлагдсан төслүүд бол 42 нь барилга байгууламж, дэд бүтцийн ангиллын төслүүд байна.

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 233 дугаар тогтоолоор шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын 79% буюу 87 төслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт, үлдсэн 21% буюу 23 төслийн худалдан авах ажиллагааг төсвийн ерөнхийлөн захирагч зохион байгуулсан байна.

Мөн эдгээр шинээр эхэлж буй 110 төслүүдийн 60 төсөл нь 686 дэд төсөл болсон бол 50 төсөл нь дангаар хэрэгжүүлэхээр байна. Түүнчлэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх хэсэгт худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгахаар зохицуулсны дагуу нийт шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан төслийн 76.7 хувь нь гэрээ байгуулсан байна.

1.5.4. Засгийн газрын гадаад зээл, тусламж

Монгол Улсын 2025 оны төсөвт нийт 1,959.4 тэрбум төгрөгийн гадаад зээл, тусламжийн төслийн санхүүжилтийг авч ашиглахаар төлөвлөгдсөнөөс 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар Засгийн газрын гадаад төслийн зээлийн ашиглалт 672.3 тэрбум төгрөг буюу 44 хувийн гүйцэтгэлтэй, тусламж 95.5 тэрбум төгрөг буюу 23 хувийн гүйцэтгэл, нийт гүйцэтгэл 767.8 тэрбум төгрөг буюу 39 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалт (тэрбум төгрөг)

Ангилал	Төслийн тоо	2025 оны батлагдсан төсөв	Ашиглалт /2025.06.19/	Хувь	Үлдэгдэл
Гадаад зээл	89	1,542.4	672.3	44%	870.1
Гадаад тусламж	27	417.0	95.5	23%	321.5
НИЙТ	116	1,959.4	767.8	39%	1,191.6

Гадаад зээл, тусламжийн төслийн санхүүжилтийг нийт 19 хөгжлийн түнш орон, олон улсын байгууллагаас хүлээн авч, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:

Хүснэгт. Гадаад зээл, тусламжийн төсөл хөтөлбөр, хөгжлийн түншээр (тэрбум төгрөг)

Д/д	Хөгжлийн түнш	Төслийн тоо	2025 онд батлагдсан ашиглалт	2025 оны санхүүжилтэд эзлэх хувь	Ашиглалт /2025.06.24/
1	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	9	431.6	22%	294.3
2	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	2	357.2	18%	119.9
3	Азийн хөгжлийн банк	50	343.1	18%	94.8

4 Бүгд Найрамдах Солонгос Улс	7	202.7	10%	69.5
5 Америкийн Нэгдсэн Улс	2	201.0	10%	55.3
6 Дэлхийн банк	12	130.3	7%	48.8
7 Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банк	13	126.1	6%	19.1
8 Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	4	46.1	2%	4.1
9 Бүгд Найрамдах Франц Улс	3	44.0	2%	33.1
10 Бүгд Найрамдах Польш Улс	2	21.0	1%	4.5
11 Япон Улс	1	16.4	1%	8.6
12 Бүгд Найрамдах Австри Улс	2	15.7	1%	9.7
13 Боловсролын Дэлхийн Түншлэл	1	8.7	0%	2.1
14 Европын Хөрөнгө Оруулалтын банк	2	8.2	0%	2.6
15 Люксембүргийн Их Гүнт Улс	1	4.5	0%	0.0
16 Кувейт	2	2.8	0%	1.0
17 Оросын Холбооны Улс	1	0.0	0%	0.0
18 Унгар Улс	1	0.0	0%	0.0
19 ХААХОУС	1	0.0	0%	0.0
НИЙТ	116	1,959.4		767.8

Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөр нь нийгэм, эдийн засгийн ач холбогдол өндөртэй томоохон бүтээн байгуулалтад чиглэж байгаа бөгөөд 2025 онд авч ашиглах нийт зээл, тусламжийн 64 хувийг 4 том хөгжлийн түнш байгууллага, улс орнууд бүрдүүлж байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зээл, тусламж 22 хувьд хүрч, энэ хүрээнд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл, Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл хэрэгжиж байгаа бол 18 хувь нь болох Бүгд Найрамдах Энэтхэг Улсын зээлээр Газрын тосны үйлдвэр барих төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Үүнээс гадна, олон улсын хөгжлийн гол түнш байгууллагууд болох Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банкны санхүүжилт өмнөх жилүүдийн адил өндөр түвшинд хадгалагдаж байгаа бөгөөд тус тус 18 болон 7 хувийг эзэлж байна.

1.5.5.Засгийн газрын өр

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 33.4 их наяд төгрөг буюу ДНБ-ий 41.8 хувьтай тэнцэж байсан бол 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 34.6 их наяд төгрөг буюу хүлээгдэж буй ДНБ-ий 38.5 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт. Засгийн газрын өрийн бүтэц (тэрбум төгрөг)

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2024	2025.I
1. Засгийн газрын өр	30,697.1	31,817.7
1.1 Дотоод өр	400.5	406.9
1.1.1 Үнэт цаас	400.5	406.9
1.2 Гадаад өр	30,296.7	31,410.8
1.2.1 Үнэт цаас	8,655.0	8,737.7
1.2.2 Зээл	21,641.6	22,673.2
2. Орон нутгийн өр	2,524.7	2,613.9
2.1 Дотоод өр	799.9	822.1
2.1.1 Үнэт цаас	799.9	822.1
2.2 Гадаад өр	1,724.9	1,791.8
2.2.1 Үнэт цаас	1,724.9	1,791.8
3. Засгийн газрын өрийн баталгаа	178.0	184.8
3.1. Засгийн газрын өрийн баталгаа	178.0	184.8
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (1+2+3)	33,399.9	34,616.3
<i>Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон өрийн хязгаар**</i>	60.0%	60.0%
<i>Засгийн газрын өр / ДНБ</i>	41.8%	38.5%*

*-ДНБ-ий хүлээгдэж буй гүйцэтгэлд харьцуулснаар.

Засгийн газрын зүгээс олон улсын хөрөнгө оруулагчидтай тогтмол мэдээлэл солилцож, олон улсын санхүүгийн зах зээлийн нөхцөл байдлыг сайтар судалсны үндсэн дээр 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр 500 сая ам.долларын хэмжээтэй, 6.625 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай “Сенчири-4” үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалж 2026 онд төлөгдөх нөхцөлтэй “Номад” бондын төлбөрөөс 391.7 сая ам.долларыг, 2028 онд төлөгдөх нөхцөлтэй “Сенчири-2” бондын төлбөрөөс 108.3 сая ам.долларыг тус тус өрийн зохицуулалт хийх замаар төлж барагдуулсан. Ингэснээр 2026 онд төлөгдөх “Номад” бондын үлдэгдэл 174.3 сая ам.доллар болж 2027 оныг хүртэл томоохон гадаад бондын төлбөрүүдийг шийдвэрлээд байна.

Засгийн газраас өрийн зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлснээр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд туссан хүүгийн төлбөр 4.1 тэрбум төгрөгөөр хэмнэгдэж байгаа бөгөөд НЗДТГ-аас 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр дотоодын зах зээлд гаргасан 298.3 тэрбум төгрөгийн үнэт цаасны 2025 онд төлөгдөх дүн болон ханшийн өсөлтөөс шалтгаалан Засгийн газрын өрийн үндсэн төлбөр 32.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

Өрийн удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийг боловсруулж, гурван жилд нэг удаа Улсын Их Хурлаар батлуулахаар заасан. Үүний дагуу 2015 оноос хойш нийт 3 удаагийн өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийг батлан, хэрэгжүүлсэн бөгөөд 4 дэх удаагийн буюу Засгийн газрын өрийн

удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийг Улсын Их Хурлын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор батлаад байна.

Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийн хүрээнд дунд хугацаанд дараах зорилтуудыг тусгасан. Үүнд:

1. Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан, эдийн засгийн бодит өгөөжтэй, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжид хэрэгжүүлэх бодлогыг баримтална.

2. Засгийн газрын өрийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлж, дунд болон урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3. Болзошгүй өр төлбөрийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн үнэт цаас болон Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлийг хязгаарлана.

4. Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаасны арилжааг тогтмолжуулан зах зээлийн суурь хүүг тогтоох замаар аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татах боломжийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулагчдын бааз суурийг тэлнэ.

Засгийн газрын өрийн нэрлэсэн илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хэмжээ 2025 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 44.5 хувьтай тэнцэхээр байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагыг хангахаар байна.

БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ТОДОТГОЛ ХИЙХ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулж Ерөнхий сайд, 19 Засгийн газрын гишүүдтэйгээр танхимаа бүрдүүлсэн болон геополитикийн хурцадмал байдал гүнзгийрч, гадаад орчны сорилт нь манай улсын эдийн засагт хүндрэлтэй нөхцөл байдал бий болгохоор байгааг харгалзан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, 34.1.4 дэх заалтын дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголын төслийг боловсрууллаа.

БҮЛЭГ 3. ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛ

3.1. Төсвийн орлого

Монгол Улсын эдийн засгийн одоогийн нөхцөл байдал, нүүрсний үнийн бууралт, нэгдсэн төсвийн орлогын эхний 5 сарын гүйцэтгэлд үндэслэн энэ оны төсвийн орлогын төсөөллийг шинэчлэн тооцлоо.

Төсвийн орлогын тооцооллыг шинэчлэн боловсруулахад дараах зарчмыг баримтлав:

- Монгол Улсын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуультай уялдуулав. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн, түүний дотор нүүрс, зэсийн үнэ, тоо хэмжээний төсөөллийг шинэчилж, төсвийн орлогын тооцоололд тусгав.
- Нүүрсний экспортыг эрчимжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, нүүрсний экспортын тоо хэмжээг өмнөх оны түвшнээс бууруулахгүй байх чиглэл баримтална. Энэ хүрээнд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, холбогдох дүрэм, журмыг өөрчилнө. Мөн нүүрс экспортын тээврийн үйл ажиллагааг сайжруулах хүрээнд хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахад анхаарч ажиллана.
- Татвар хураалтыг сайжруулах, татварын өр нэмж үүсэхээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Ялангуяа, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн татварын өр төлбөрийг барагдуулах, цаашид татварын өр төлбөр үүсгэхгүй байх чиглэлээр ажиллана. Албан бус, бүртгэлгүй хийгдэж буй ажил гүйлгээг бүртгэл, татварт хамруулах чиглэлээр үе шаттай арга хэмжээ зохион байгуулж, татварын орлогын бааз суурийг тэлэх, эх үүсвэрийг бүрэн дайчилна.
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн улсын төсөвт болон Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх ногдол ашгийн орлогыг бууруулахгүй байхаар тооцов.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн нийт орлого батлагдсан дүнгээс 3,895.4 тэрбум төгрөгөөр буурч, 32,540.2 тэрбум төгрөгт, тэнцвэржүүлсэн орлого батлагдсан дүнгээс 3,260.0 тэрбум төгрөгөөр буурч, 30,209.9 тэрбум төгрөгт тус тус хүрэхээр байна. Төсвийн орлогын төсөөллийг ийнхүү шинэчлэхэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого, нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын бууралт голлон нөлөө үзүүлэхээр байна.

Хүснэгт. 2025 оны нэгдсэн төсвийн орлогын хүлээгдэж буй гүйцэтгэл (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2025 БАТ	2025 ХБГ	ЗӨРҮҮ
Нийт орлого	36,435.6	32,540.2	-3,895.4

Тогтворжуулалтын сан	608.9	429.1	-179.8
Үндэсний баялгийн сан	2,356.8	1,901.2	-455.6
Тэнцвэржүүлсэн орлого	33,469.9	30,209.9	-3,260.0

3.2. Төсвийн урсгал зарлага

Төсвийн тодотголд урсгал зарлагыг дараах зарчмын дагуу буурууллаа. Үүнд:

1. Төрийн албаны бүтцийг цомхон, чадварлаг байлгах, төрийн албаны удирдах, гүйцэтгэх орон тооны бүтцийн зөв харьцааг тогтоох, чиг үүргийн давхардлыг арилгах, тэвчиж болох зардлыг хэмнэх, төрийн үйлчилгээг цахимжуулах замаар төрийн албаны орон тоог бууруулах боломжтой гэж үзсэн тул багш, эмчээс бусад төрийн албан хаагчдыг 9 хувиар бууруулахад 261.0 тэрбум төгрөг;

2. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлттэй уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагч хооронд чиг үүрэг, бүтэц шилжүүлэх 8.4 тэрбум төгрөг;

3. Төрийн албаны үйл ажиллагааг цахимжуулах, бичиг хэргийг цахимаар хөтлөн явуулах, тавилга, багаж хэрэгсэл худалдан авалгүй тэвчих зэргээр төсвийн байгууллагуудад үйл ажиллагааны зардлын хэмнэлт бий болгох 104.4 тэрбум төгрөг;

4. Салбаруудад хэрэгжиж байгаа хөтөлбөр, арга хэмжээний 7 дугаар сараас эхлэн он дуустал зардлыг хэмнэх, харин 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж холбогдох төсвийг тусгасан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа хөтөлбөр, арга хэмжээний зардлыг бүрэн байдлаар хэмнэх 617.3 тэрбум төгрөг;

Дээрх зарчмыг баримтлан төсвийн тодотголд урсгал зарлагын холбогдох өөрчлөлтүүдийг тусгаснаар төрийн чиг үүргийг оновчтой зохион байгуулж, цомхон, чадварлаг бүтцээр төрийн үйлчилгээг үр ашигтай хүргэх, удирдах, гүйцэтгэх ажилтны зохистой харьцааг тогтоох, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж хүнд суртал, шат дамжлагыг бууруулах зэрэг бодитой өөрчлөлтүүд гарна гэж тооцлоо.

3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл тусламжийн ашиглалт:

3.3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.1.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу 2025 оны 05 дугаар сарын 31-ний дотор худалдан авах ажиллагааг бүрэн дуусгах, гэрээ байгуулаагүй төслүүдийн санхүүжилтийг хэмнэлтэд тооцох, зарцуулахгүй байх зохицуулалтын хүрээнд “Төсвийн хэмнэлтэд тооцох тухай” тогтоолыг Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж баталсан.


Уг тогтоолын хүрээнд Эрүүл мэндийн сайдын багцаас 69.9 тэрбум төгрөг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын багцаас 57.7 тэрбум төгрөг,

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцаас 36.6 тэрбум төгрөг, Боловсролын сайдын багцаас 33.7 тэрбум төгрөг, Зам, тээврийн сайдын багцаас 33.4 тэрбум төгрөг, Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын багцаас 19.7 тэрбум төгрөг, Монгол Улсын тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцаас 17.4 тэрбум төгрөг, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын багцаас 12.4 тэрбум төгрөг, бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцаас 255.4 тэрбум төгрөг, нийт 535.9 тэрбум төгрөгийг төсвийн хэмнэлтэд тооцсон.

Түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын Байнгын Нарийн бичгийн дарга нарын газар хооронд 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан хэлэлцээрийн хүрээнд COP-17 дугаар Бага хурлыг 2026 оны 8 дугаар сард Монгол Улсад зохион байгуулахтай холбогдуулан хурлын бэлтгэл ажилд шаардагдах хөрөнгө оруулалтад 41.8 тэрбум төгрөг, мөн Эрчим хүчний сайдын багцад “ДЦС-3” ТӨХК-ийн өндөр даралтын турбин цехийн барилга байгууламжид 2025 оны 06 сарын дугаар сарын 03-нд шилжих шөнө гэнэтийн аваар осол, гал гарч томоохон эрсдэл үүссэнтэй холбогдуулан ослын хохирол, хор уршгийг бууруулах, өвлийн их ачаалалд дулаанжуулалтын тоноглолын бэлэн байдлыг хангах зайлшгүй шаардлагын хүрээнд 35.5 тэрбум төгрөг, нийт 77.3 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын зардалд нэмж тусгалаа.

Ингэснээр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8,994.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 612 төсөл, арга хэмжээнд 2,982.6 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр байна.

Зураг. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, 2020-2025 он (тэрбум төгрөг)



Хүснэгт. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, салбараар

Төсвийн ерөнхийлөн захирагч	Төслийн тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Монгол Улсын Ерөнхийлөгч	2	694.1	694.1
Монгол Улсын Их Хурлын дарга	1	8,560.0	8,560.0
Монгол Улсын Ерөнхий Сайд	1	1,433.5	1,433.5
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	5	174,732.6	36,407.0

Монгол Улсын Шадар сайд	7	56,308.1	41,553.1
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	17	60,908.3	23,167.0
Гадаад харилцааны сайд	2	9,569.6	9,569.6
Сангийн сайд	10	142,790.2	127,720.2
Хууль зүй, дотоод хэргийн сайд	18	144,460.5	104,720.7
Батлан хамгаалахын сайд	4	105,436.1	65,803.9
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	13	72,694.4	64,902.5
Боловсролын сайд	184	1,282,891.8	438,952.9
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	24	135,833.9	48,728.1
Зам, тээврийн сайд	95	3,505,527.0	918,076.2
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	48	435,438.8	125,564.5
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	56	1,064,339.3	332,991.3
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	17	141,359.2	56,284.2
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	5	35,293.8	23,362.8
Эрчим хүчний сайд	42	741,016.5	229,421.9
Эрүүл мэндийн сайд	37	357,685.7	123,207.2
Авлигатай тэмцэх газрын дарга	2	2,285.1	2,285.1
Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	3	6,006.7	4,089.7
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	7	132,300.5	52,748.6
Улсын Ерөнхий Прокурор	5	73,139.7	29,838.3
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	1	243.4	243.4
Шүүхийн сахилгын хорооны дарга	1	300.0	300.0
Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга	1	2,271.6	2,271.6
Үндэсний Статистикийн Хорооны дарга	1	1,804.2	1,804.2
Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	1	779.5	779.5
Улсын төсөв	610	8,696,104.1	2,875,481.1
Концесс	2	298,384.7	107,132.1
НИЙТ	612	8,994,488.8	2,982,613.2

1.5.6.Засгийн газрын гадаад зээл, тусламж

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад нийт 1,959.4 тэрбум төгрөг батлагдсанаас 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар гүйцэтгэл 39.2 хувь буюу гадаад зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт 767.8 тэрбум төгрөг байна.

Хүснэгт. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт (тэрбум төгрөг)

Ангилал	Төслийн тоо	2025 оны батлагдсан төсөв	Ашиглалт /2025.06.24/	Хувь	Үлдэгдэл
Гадаад зээл	89	1,542.4	672.3	44%	870.1
Гадаад тусламж	27	417.0	95.5	23%	321.5
НИЙТ	116	1,959.4	767.8	39%	1,191.6

Гадаад зээл, тусламжийн төслийн санхүүжилтийг нийт 19 хөгжлийн түнш орон, олон улсын байгууллагаас хүлээн авч, 116 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Үүнд:

Хүснэгт. Гадаад зээл, тусламжийн төсөл хөтөлбөр, хөгжлийн түншээр (тэрбум төгрөг)

Д/д	Хөгжлийн түнш	Төслийн тоо	2025 онд батлагдсан ашиглалт	2025 оны санхүүжилтэд эзлэх хувь	Ашиглалт /2025.06.24/
1	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	9	431.6	22%	294.3
2	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	2	357.2	18%	119.9
3	Азийн хөгжлийн банк	50	343.1	18%	94.8
4	Бүгд Найрамдах Солонгос Улс	7	202.7	10%	69.5
5	Америкийн Нэгдсэн Улс	2	201.0	10%	55.3
6	Дэлхийн банк	12	130.3	7%	48.8
7	Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банк	13	126.1	6%	19.1
8	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	4	46.1	2%	4.1
9	Бүгд Найрамдах Франц Улс	3	44.0	2%	33.1
10	Бүгд Найрамдах Польш Улс	2	21.0	1%	4.5
11	Япон Улс	1	16.4	1%	8.6
12	Бүгд Найрамдах Австри Улс	2	15.7	1%	9.7
13	Боловсролын Дэлхийн Түншлэл	1	8.7	0%	2.1
14	Европын Хөрөнгө Оруулалтын банк	2	8.2	0%	2.6
15	Люксембургийн Их Гүнт Улс	1	4.5	0%	0.0
16	Кувейт	2	2.8	0%	1.0
17	Оросын Холбооны Улс	1	0.0	0%	0.0
18	Унгар Улс	1	0.0	0%	0.0
19	ХААХОУС	1	0.0	0%	0.0
	НИЙТ	116	1,959.4		767.8

“Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төсөл, хөтөлбөр нь нийгэм, эдийн засгийн ач холбогдол өндөртэй томоохон бүтээн байгуулалтад чиглэж байгаа бөгөөд 2025 онд авч ашиглах нийт зээл, тусламжийн 64 хувийг 4 том хөгжлийн түнш байгууллага, улс орнууд бүрдүүлж байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зээл, тусламж 22 хувьд хүрч, энэ хүрээнд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл, Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл хэрэгжиж байгаа бол 18 хувь нь болох Бүгд Найрамдах Энэтхэг Улсын зээлээр Газрын тосны үйлдвэр барих төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Үүнээс гадна, олон улсын хөгжлийн гол түнш байгууллагууд болох Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банкны санхүүжилт өмнөх жилүүдийн адил өндөр түвшинд хадгалагдаж байгаа бөгөөд тус тус 18 болон 7 хувийг эзэлж байна.”

Гадаад зээл, тусламжийн эх үүсвэр нь улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилтыг хангах болон эдийн засаг, нийгмийн хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэсээр ирсэн бөгөөд цаашид ч бодит эдийн засгийн

өсөлтийг дэмжих, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, урт хугацааны тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, дэд бүтцийн томоохон төслүүд хэрэгжиж байна.

Хүснэгт. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийн ашиглалт, төслөөр (тэрбум төгрөг)

Ангилал	Төслийн нэр	Амлалтын дүн	Ашиглах үлдэгдэл	2025 батлагдсан	Үлдэгдэл
500.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй	Газрын тос боловсруулах үйлдвэр	5,808.6	4,889.5	346.5	4,543.0
	Эрдэнэбүрэн УЦС	865.8	865.8	271.6	594.2
	Солонго 1, 2 хороолол	912.9	550.4	135.0	415.4
	Төв цэвэрлэх байгууламж	853.7	129.3	80.0	49.3
	Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арлалтын төсөл - 3	513.1	501.5	49.7	451.8
Бусад 67 төсөл		8,898.5	5,665.1	659.6	5,005.5
НИЙТ		17,876.5	12,601.6	1,542.4	11,059.2

“Дээрх хүснэгтэд харуулснаар гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй 500.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 5 төсөл нь 2025 онд батлагдсан нийт гадаад зээлийн ашиглалтын 57 хувийг дангаараа эзэлж байна.”

Хүснэгт. Засгийн газрын гадаад тусламжийн ашиглалт, төсөл, арга хэмжээгээр (тэрбум төгрөг)

Ангилал	Төслийн нэр	Амлалтын дүн	Ашиглах үлдэгдэл	2025 батлагдсан	Үлдэгдэл
Нийт тусламжийн 60% - 1 төсөл	УБ хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл /МСС/	1,197.2	391.8	187.9	203.9
Бусад 23 төсөл		666.0	528.3	188.9	339.4
НИЙТ		2,017.2	1,012.8	417.0	595.8

“Гадаад тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн нийт амлалтын дүнгийн 60 хувийг АНУ-ын Мянганы Сорилтын Сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл дангаар эзэлж байна.”

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2024 оны 54 дүгээр тогтоолд гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийн эрэмбийг гаргаж, удаашралтай байгаа төслүүдийг цаашид хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулан танилцуулах, мөн УИХ-ын 2024 оны 81 дүгээр тогтоолоор төслүүдийн үр дүн, үр ашигт дүн шинжилгээ хийх, гадаад зээлийн хөрөнгөөр зөвлөх үйлчилгээ, төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал зэрэг урсгал зардлыг цаашид санхүүжүүлэхгүй байх чиглэлийг баримтлан ажиллаж байна.

Эдгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2025 онд гадаад зээлийн төслүүдийг үр ашиг, ач холбогдлоор нь эрэмбэлж, нийт 1,542.5 тэрбум төгрөгийн хүрээнд санхүүжихээр төлөвлөсөн боловч зарим шаардлагагүй шинэ худалдан авалт болон зарим зөвлөх үйлчилгээний гэрээний санхүүжилтийг зогсоох, хойшлуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд нийт 173.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хойшлуулж, Засгийн газрын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт туссан үндэсний хэмжээний дэд бүтэц, бүтээн байгуулалтын мега төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлэх зохицуулалт хийсэн.

Монгол Улсын Их Хурлаар холбогдох зээлийн хэлэлцээр нь соёрхон батлагдаж, Засгийн газраас хэрэгжүүлж буй нийт 72 гадаад зээлийн төсөл, арга хэмжээ байгаа бөгөөд нийт амлалтын дүнгээс 70.4 хувь нь ашиглагдаагүй буюу 12.6 их наяд төгрөг ашиглахаар хүлээгдэж байна. Эдгээр төслүүдийн 82 хувь нь 2025–2028 онд хэрэгжиж дуусах гэрээ, хэлэлцээртэй тул энэ хугацаанд гадаад зээлийн ашиглалтыг зайлшгүй нэмэгдүүлж, төслүүдийг үр дүнтэй, цаг хугацаанд нь хэрэгжүүлж дуусгах шаардлага тулгарч байна.

Иймд 2025 оны төсвийн тодотголд гадаад зээл, тусламжийн эх үүсвэрийн ашиглалтыг **бууруулахгүй байх зарчим** баримталсан. Ингэснээр:

- ✓ Гадаад зээлийн төслүүдийг цаг хугацаанд нь ашиглалтад оруулах,
- ✓ Олон улсын гэрээний үүргээ хангах,
- ✓ Төсөл, хөтөлбөрүүдийг гэрээнд заасан хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх,
- ✓ Улсын хөгжлийн зорилтуудыг биелүүлэх,
- ✓ Гадаад зээлийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах зэрэг нөхцөлийг бүрдүүлэх юм.

БҮЛЭГ 4. НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

4.1. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 30,209.9 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн суурь зарлага 28,401.7 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,808.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувийн ашигтай байхаар тооцлоо.

Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн үзүүлэлт (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2025 БАТ	2025 ТОД	ЗӨРҮҮ
НИЙТ ОРЛОГО	36,435.6	32,540.2	-3,895.4
Тогтворжуулалтын сан	608.9	429.1	-179.8
Үндэсний баялгийн сан	2,356.8	1,901.2	-455.6
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО	33,469.9	30,209.9	-3,260.0
НИЙТ ЗАРЛАГА	33,431.5	31,575.1	-1,856.4
Урсгал зардал	25,304.6	24,005.5	-1,299.1
Хөрөнгийн зардал	8,340.3	7,841.4	-499.0
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-213.4	-271.8	-58.4
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	38.3	-1,365.2	-1,403.5
ДНБ-д эзлэх хувь	0.0%	-1.5%	-1.5%
СУУРЬ ЗАРЛАГА	30,258.1	28,401.7	-1,856.4
ДНБ-д эзлэх хувь	31.9%	31.6%	0.3%
СУУРЬ ТЭНЦЭЛ	3,211.8	1,808.2	-1,403.5
ДНБ-д эзлэх хувь	3.4%	2.0%	-1.5%

4.2. Төсвийн тусгай шаардлага

Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2025 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 7,491.7 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 129.0 ам.доллар байхаар тооцлоо.

Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасны дагуу нэгдсэн төсвийн суурь тэнцэл ДНБ-ий 2.0 хувьтай тэнцэхээр төлөвлөлөө.

Хүснэгт. Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн ДНБ-д эзлэх хувь

	2025
Хуулийн хязгаар	2.0%
Төсөөлөл	2.0%

Тухайн жилийн нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т заасны дагуу урсгал зарлагыг ДНБ-ий 26.7 хувьтай тэнцэхээр төлөвлөлөө.

Хүснэгт. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын ДНБ-д эзлэх хувь

	2025
Хуулийн хязгаар	30.0%
Төсөөлөл	26.7%

Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-д заасны дагуу Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2025 онд хуульд заасан хязгаарт байхаар байна.

Хүснэгт. Засгийн газрын өрийн төсөөлөл, нэрлэсэн дүнгээр (ДНБ-д эзлэх хувь)

	2025
Хуулийн хязгаар	60.0%
Төсөөлөл	44.5%

---oOo---